СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/69/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баруун-Урт сум<br>2023 он | Дарга,<br>тэргүүлэх аудитор: М.Нарантуяа<br>Утас: 70518396<br>Аудитын менежер: Г.Даваа<br>Утас: 70512123<br>Аудитор: Ө.Золзаяа<br>Утас: 70512127 |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 5

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 11

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 11

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 11

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 11

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 11

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 12

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 13

**4.1 Ерөнхий зүйл** ..... 13

**4.2 Материаллаг байдал** ..... 13

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 14

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** 14

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 14

*Шийдвэрлэсэн байдал:* Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах зөвлөмж өглөө. ..... 14

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 14

**4.5.1 Завсрын аудитын талаар** ..... 14

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 15

**5.1 Төлбөрийн акт** ..... 15

**5.2 Албан шаардлага** ..... 15

**5.1 Зөвлөмж** ..... 15

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 16


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.03.24 № 65

танай ____________-ны №____________-т

СҮХБААТАР АЙМГИЙН АСГАТ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Б.СУМЪЯАСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Сүхбаатар аймгийн Асгат сумын эрүүл мэндийн төв эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулагдаагүй 35,138.3 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 2022 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоож, үр дүн, гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА

D:/Bichig hereg/2023/A4 toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **164,128,876.26** | **117,641,903.58** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 884,688.36 | 35,138,335.82 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 884,688.36 | 35,138,335.82 |
| **3121** | **Төгрөг** | 884,688.36 | 35,138,335.82 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 7,533.36 | 35,138,335.82 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 877,155.00 | - |
| **33** | **АВЛАГА** | 100,839,500.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 100,839,500.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 100,839,500.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 62,404,687.90 | 82,503,567.76 |
| **351** | **Түүхий эд материал** | 30,789,598.70 | 44,912,153.76 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 9,495,355.00 | 22,634,543.00 |
| 35130 | Эм боох материал | 21,294,243.70 | 22,277,610.76 |
| **354** | **Хангамжийн материал** | 26,965,089.20 | 29,951,414.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,533,700.00 | 4,161,850.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,838,300.00 | 2,468,540.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,752,268.00 | 3,589,660.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 50,000.00 | 780,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,986,971.20 | 1,002,964.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 13,803,850.00 | 17,948,400.00 |
| 35600 | Мал амьтад | 4,650,000.00 | 7,640,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **477,492,901.55** | **642,821,535.39** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 477,492,901.55 | 642,821,535.39 |
| **392** | **Биет хөрөнгө** | 465,994,901.55 | 628,776,535.39 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 365,471,416.58 | 365,471,416.58 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (35,421,342.48) | (49,016,977.56) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 61,347,183.00 | 61,347,183.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (40,557,183.00) | (43,527,183.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 120,012,040.26 | 204,103,913.10 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (74,435,698.64) | (62,429,643.68) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 49,979,329.91 | 77,929,957.56 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (42,777,714.56) | (8,550,784.16) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 95,464,500.00 | 113,401,200.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (33,087,629.52) | (29,952,546.45) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 11,498,000.00 | 14,045,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,219,500.00 | 2,547,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,219,500.00) | - |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11,498,000.00 | 11,498,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **641,621,777.81** | **760,463,438.97** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **641,621,777.81** | **760,463,438.97** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 641,621,777.81 | 760,463,438.97 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 429,266,250.98 | 429,266,250.98 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | 429,266,250.98 | 429,266,250.98 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 212,355,526.83 | 331,197,187.99 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 212,355,526.83 | 212,355,526.83 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 118,841,661.16 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **641,621,777.81** | **760,463,438.97** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 772,876,142.2 | 770,431,702.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 79,215,615.2 | 164,251,262.0 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 79,215,615.2 | 164,251,262.0 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 79,215,615.2 | 708,000.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 708,000.0 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 79,215,615.2 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 129,110,241.0 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 34,433,021.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 693,660,527.0 | 606,180,440.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 378,612,000.0 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 378,612,000.0 | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 271,653,627.0 | |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,550,000.0 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 27,540,427.0 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 241,563,200.0 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 28,367,400.0 | 31,826,000.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,367,400.0 | 31,826,000.0 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 15,027,500.0 | 574,354,440.0 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 15,027,500.0 | 574,354,440.0 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 600,726,675.3 | 651,460,832.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 600,726,675.3 | 651,460,832.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 560,783,146.2 | 628,842,119.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 297,076,717.1 | 318,810,933.3 |
| 210101 | Үндсэн цалин | 166,261,939.7 | 221,217,455.2 |
| 210102 | Нэмэгдэл | 76,002,989.6 | 60,993,739.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,222,000.0 | 4,904,000.0 |
| 210104 | Урамшуулал | 51,589,787.8 | 31,695,738.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,474,004.5 | 39,942,787.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,822,104.4 | 27,377,427.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,459,015.6 | 3,172,865.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,926,812.5 | 2,504,792.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 478,797.5 | 625,873.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,787,274.5 | 6,261,830.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15,294,700.9 | 13,182,627.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,619,334.9 | 6,592,035.0 |
| 210302 | Түлш, халаалт | 8,675,366.0 | 6,511,392.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 79,200.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 21,417,828.0 | 28,769,469.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,698,095.0 | 6,493,630.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,453,613.0 | 19,911,051.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,290,000.0 | 1,884,788.5 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 976,120.0 | 480,000.0 |
| 2105 | Нормативт зардал | 120,039,375.1 | 111,009,828.1 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 104,079,474.3 | 85,537,010.9 |
| 210502 | Хоол, хүнс | 11,576,580.8 | 17,310,107.2 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,383,320.0 | 8,162,710.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 16,055,700.0 | 30,924,840.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,163,300.0 | 9,039,600.0 |
| 210602 | Тавилга | 157,350.0 | 581,500.0 |
| 210604 | Урсгал засвар | 9,735,050.0 | 21,303,740.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 154,000.0 | 112,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 154,000.0 | 112,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 15,579,983.0 | 17,094,235.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,579,983.0 | 17,094,235.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,690,837.6 | 68,995,398.8 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,499,460.0 | 7,286,000.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 37,191,377.6 | 61,709,398.8 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 39,943,529.1 | 22,618,713.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 32,430,950.0 | 14,998,360.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 32,430,950.0 | 14,998,360.0 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | | 7,620,353.0 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 7,620,353.0 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 7,512,579.1 | |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,512,579.1 | |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 172,149,466.9 | 118,970,869.5 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 130,499.7 | 129,208.3 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 130,499.7 | 129,208.3 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (130,499.7) | (129,208.3) |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 172,018,967.2 | 118,841,661.2 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 633,921,027.00 | 666,627,940.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 708,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 708,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 708,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 708,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 633,921,027.00 | 665,919,940.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 378,612,000.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 378,612,000.00 | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 211,914,127.00 | |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,550,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 27,540,427.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 181,823,700.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 28,367,400.00 | 31,826,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 28,367,400.00 | 31,826,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 15,027,500.00 | 634,093,940.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 15,027,500.00 | 634,093,940.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 588,967,838.64 | 575,417,292.54 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 588,967,838.64 | 575,417,292.54 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 549,024,309.51 | 552,798,579.56 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 297,076,717.14 | 318,810,933.25 |
| 210101 | Үндсэн цалин | 166,261,939.69 | 221,217,455.15 |
| 210102 | Нэмэгдэл | 76,002,989.64 | 60,993,739.45 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,222,000.00 | 4,904,000.00 |
| 210104 | Урамшуулал | 51,589,787.81 | 31,695,738.65 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,474,004.50 | 39,942,787.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,822,104.41 | 27,377,427.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,459,015.61 | 3,172,865.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,926,812.51 | 2,504,791.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 478,797.45 | 625,873.09 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,787,274.52 | 6,261,830.20 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15,854,820.87 | 14,710,647.02 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,619,334.87 | 6,592,035.02 |
| 210302 | Түлш, халаалт | 9,235,486.00 | 8,039,412.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 79,200.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 25,624,715.00 | 28,851,991.46 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,201,795.00 | 7,044,780.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,156,800.00 | 19,220,423.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,290,000.00 | 2,106,788.46 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 976,120.00 | 480,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 92,411,959.00 | 98,872,395.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 73,416,579.00 | 73,526,545.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,488,390.00 | 15,487,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,506,990.00 | 9,858,350.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 62,848,650.00 | 31,724,590.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 47,780,900.00 | 9,039,600.00 |
| 210602 | Тавилга | 1,078,300.00 | 380,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,989,450.00 | 21,304,990.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 154,000.00 | 112,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 154,000.00 | 112,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 15,579,983.00 | 17,237,235.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,579,983.00 | 17,237,235.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,999,460.00 | 2,536,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,999,460.00 | 2,536,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 39,943,529.13 | 22,618,712.98 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 32,430,950.00 | 14,998,360.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 32,430,950.00 | 14,998,360.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | | 7,620,352.98 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 7,620,352.98 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 7,512,579.13 | |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,512,579.13 | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 44,953,188.36 | 91,210,647.46 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 44,068,500.00 | 56,957,000.00 |
| 22 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авах | 44,068,500.00 | 56,957,000.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 44,068,500.00 | 56,957,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 44,068,500.00 | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 56,957,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -44,068,500.00 | -56,957,000.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 884,688.36 | 34,253,647.46 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 884,688.36 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 35,138,335.82 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 429,266,250.98 | - | 40,336,559.62 | | 469,602,810.60 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **429,266,250.98** | **-** | **40,336,559.62** | **-** | 469,602,810.60 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 172,018,967.21 | | 172,018,967.21 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **429,266,250.98** | **-** | **212,355,526.83** | **-** | 641,621,777.81 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **429,266,250.98** | **-** | **212,355,526.83** | **-** | 641,621,777.81 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **429,266,250.98** | **-** | **212,355,526.83** | **-** | 641,621,777.81 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 118,841,661.16 | | 118,841,661.16 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **429,266,250.98** | **-** | **331,197,187.99** | **-** | 760,463,438.97 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| | Үзүүлэлт | Тайлант оны |
|---|---|---|

| Эдийн засгийн ангилал | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 644,044,400.0 | 607,882,564.6 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 644,044,400.0 | 607,882,564.6 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 644,044,400.0 | 592,884,204.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 437,692,400.0 | 316,011,008.3 |
| 210101 | Үндсэн цалин | 275,322,400.0 | 221,217,455.2 |
| 210102 | Нэмэгдэл | 124,791,600.0 | 60,993,739.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,891,300.0 | 4,904,000.0 |
| 210104 | Урамшуулал | 31,687,100.0 | 28,895,813.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 56,194,300.0 | 39,942,787.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,211,900.0 | 27,377,427.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,495,600.0 | 3,172,865.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,596,600.0 | 2,504,792.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 898,900.0 | 625,873.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,991,300.0 | 6,261,830.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,435,000.0 | 14,710,647.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,490,000.0 | 6,592,035.0 |
| 210302 | Түлш, халаалт | 16,345,000.0 | 8,039,412.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,600,000.0 | 79,200.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,732,300.0 | 26,275,991.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,396,700.0 | 5,044,780.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,600,000.0 | 18,644,423.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,963,400.0 | 2,106,788.5 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 772,200.0 | 480,000.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 39,201,600.0 | 87,876,945.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 28,338,900.0 | 65,526,545.0 |
| 210502 | Хоол, хүнс | 4,694,000.0 | 14,490,500.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,168,700.0 | 7,859,900.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 22,522,500.0 | 63,234,590.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,522,500.0 | 16,761,600.0 |
| 210602 | Тавилга | 1,000,000.0 | 8,474,000.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,000,000.0 | 1,000,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 7,000,000.0 | 36,998,990.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 379,400.0 | 112,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 379,400.0 | 112,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 34,162,900.0 | 40,784,235.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 28,867,900.0 | 36,289,235.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,295,000.0 | 4,495,000.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,724,000.0 | 3,936,000.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,724,000.0 | 3,936,000.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 14,998,360.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 14,998,360.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 14,998,360.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 644,044,400.0 | 606,888,440.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 37,730,000.0 | 31,826,000.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 37,730,000.0 | 31,826,000.0 |

| | | | |
|---|---|---|---|
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 606,314,400.0 | 575,062,440.0 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 606,314,400.0 | 575,062,440.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **7,533.4** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **35,138,335.8** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төв "Үйлчлэх хүрээний хүн амд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэвшилтэд технологид тулгуурлан тэгш хүртээмжтэй, хэнийг ч орхигдуулалгүй үзүүлэхэд оршино" эрхэм зорилгын хүрээнд хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоол "Жагсаалт, төлбөрийн хэмжээ,төлбөрийн арга, журам шинэчлэн батлах журам"
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дүгээр тогтоол "Багц,төлбөрийн хэмжээ,журам батлах тухай"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 118 мянган төгрөгөөр буюу 18.52 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| ***Үзүүлэлт*** | ***Эхний үлдэгдэл*** | ***Эцсийн үлдэгдэл*** | ***Өөрчлөлт*** |
|---|---|---|---|
| ***Б*** | 1 | 2 | 3=2-1 |
| ***Мөнгөн хөрөнгө*** | 884.7 | 35,138.3 | 34,253.6 |
| ***Авлага*** | 100,839.5 | - | (100,839.5) |
| ***Бараа материал*** | 62,404.7 | 82,503.6 | 20,098.9 |
| ***Үндсэн хөрөнгө*** | 477,492.9 | 642,821.5 | 165,328.6 |
| ***Нийт хөрөнгө*** | **641,621.8** | **760,463.4** | **118,841.7** |
| ***Өр төлбөр*** | - | - | - |
| ***Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/*** | 641,621.8 | 760,463.4 | 118,841.7 |
| ***Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн*** | **641,621.8** | **760,463.4** | **118,841.7** |

- *Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 34,253.6 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үлдэгдэл байна.*
- *Авлагын данс 100,839.5 мянган төгрөгөөр буурссан нь өмнөх оны эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага барагдсан нь нөлөөлсөн байна.*
- *Үндсэн хөрөнгө данс 642,281.5 мянган төгрөг болж 165,328.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 56,957.0, үнэ төлбөргүй 69,923.4, шилжүүлж авсан 41,100.0, дахин үнэлгээний нэмэгдэл 59,186.4 мянга нийт 227,167.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 95,860.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, хөрөнгийн элэгдлээр буурсан байна.*
- *Засгийн газрын хувь оролцоо данс 118,841.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.*

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн салбарын төсвийн төсөл боловсруулах процесс өөрчлөгдөж ЭМДС-ийн санхүүжилтийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 01, 05 дугаар тогтоолын дагуу хүн амын тоо, насны ангилал, хүйс, хот хоорондын зайнаас хамааруулж нэг иргэнд ноогдох норматив зардал болон үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тухайн жилийн тоон үзүүлэлтэд тулгуулан төсвийн төслийг боловсруулжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг ЭМДС-аас 606,314.4 мянга, орон нутгийн санхүүжилт 37,730.0 мянга нийт 644,044.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 607,882.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 607,882.6 мянган төгрөг буюу 94 хувьтай зарцуулсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 32,435.00 | 27,331.00 | 5,104.00 | 84 |
| 2 | 83201- Ангилагдаагүй бусад зориулалт | 5,295.00 | 4,495.00 | 800.00 | 85 |
| 3 | 80302-Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон | 165,954.60 | 161,536.20 | 4,418.40 | 97 |
| 4 | 81603-Үндсэн мэргэжлийн тусламж | 308,634.20 | 286,082.60 | 22,551.60 | 93 |
| 5 | 83603-Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан | 131,725.60 | 128,437.80 | 3,287.80 | 98 |
| НИЙТ | | 644,044.4 | 607,882.6 | 36,161.8 | 94 |

Нэг иргэнд ноогдох нормативаар тооцсон, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтээс 36,161.8 мянган төгрөг хэмнэгдсэн байна. Энэ нь боловсон хүчин дутмаг, зарим эрүүл мэндийн тусламж үйлчилгээ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын шалгуурт нийцээгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### *3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ө.Золзаяа, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 600,726.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 12,014.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоов.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1[1], 15,2.3[2]-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 2,112.1 мянган төгрөгөөр буурч, хангамж, бараа материалын зардлууд 7,351.6 мянган төгрөгөөр өссөн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн сайтад тайлант хугацаанд оруулах 144 мэдээллээс 4 мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн байна.

*Шийдвэрлэсэн байдал:* Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах зөвлөмж өглөө.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар
Сүхбаатар аймгийн Асгат сумын Эрүүл мэндийн төвд завсрын аудит хийгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

*Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.*

*Хүснэгт 3* Албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| **Төлбөрийн акт** | 1 | 300.0 | 1 | 300.0 | 100 |
| **Зөвлөмж** | 2 | - | 2 | - | 100 |
| Нийт дүн | **3** | - | **3** | - | **100** |

[1] байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;
[2] сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,732.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,148.6 мянган төгрөгийн зөрчил[3]-д төлбөрийн акт тогтоож, 7,574.7 мянган төгрөгийн зөрчлийн таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулж байх зөвлөмж өглөө..

### 5.1 Төлбөрийн акт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн захирамжилсан шийдвэр /*орлогын төлөвлөгөө болон ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулах*/ гараагүй байхад сумын Засаг даргын захирамжаар Төсвийн шууд захирагчийн цалинг 2,000.0 мянган төгрөг буюу 114 хувиар нэмэгдүүлэн тогтоож, төсвөөс 2,148.6 мянган төгрөгийг илүү олгосон байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх /*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;*/, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь /*Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах*/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь /*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;*/, Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 2 дугаар заалт /*салбарын онцлог, гүйцэтгэлд суурилсан үр дүнг үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг цалингийн доод хэмжээнээс нэмэгдүүлэх асуудлыг тухайн жилийн батлагдсан төсвийн багцынхаа хүрээнд зохицуулж шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрсүгэй*/ -ыг тус тус зөрчсөн байна.

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Санхүүгийн тайланд өглөгөөр тайлагнаагүй, өмнөх оны хатгалтын хөлс 3,525.1 төгрөг олгосон байна.

5.2.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэр гараагүй байхад эрүүл мэндийн төвийн ажилчдын цалинг 10-20 хувиар нэмэгдүүлж, төсвийг 4,049.6 мянган төгрөгөөр илүү зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь / Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх / Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/ , Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 2.2 дахь /батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах/, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх /*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;*/, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь /*Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах*/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь /*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;*/, Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 2 дугаар заалт /*салбарын онцлог, гүйцэтгэлд суурилсан үр дүнг үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг цалингийн доод хэмжээнээс нэмэгдүүлэх асуудлыг тухайн жилийн батлагдсан төсвийн багцынхаа хүрээнд зохицуулж шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрсүгэй*/ заалтуудыг тус тус зөрчсөн байна.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. *Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

[3] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*<u>Илрүүлэлт:</u>* Шилэн дансны нэгдсэн сайтад тайлант хугацаанд оруулах 144 мэдээллээс 4 мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>* Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

| /мянган төгрөгөөр/ | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зөрчлийн товч утга** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалинг үндэслэлгүй нэмж тогтоосон | 1 | 2,148.6 | 1 | 2,148.6 | | | | | | | | |
| Цалин хөлс илүү олгосон | 1 | 4,049.6 | | | 1 | 4,049.6 | | | | | | |
| Өмнөх оны өглөгийг санхүүгийн тайланд илэрхийлээгүй | 1 | 3,525.1 | | | 1 | 3,525.1 | | | | | | |
| Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **4** | **9,732.2** | 1 | 2148.6 | **2** | **7,574.7** | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** |